



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/36

Хэрлэн сум

Захирамжид өөрчлөгт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, Засгийн газрын 2011 оны 323 дугаар тогтоолоор батлагдсан "Жендэрийн үндэсний хорооны дүрэм"-ийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Салбар хороог шинэчлэх тухай аймгийн Засаг даргын 2016 оны 499 дугаар захирамжийн Нэгдүгээр хавсралтад өөрчлөлт оруулж, хавсралтаар баталсугай.

2. Салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулж, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг салбар хорооны зохицуулагч Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогду /лан аймгийн Засаг даргын 2016 оны 499 дугаар захирамжийн Нэгдүгээр хавсралтыг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 23 өдрийн 9/3
дугаар захирамжийн хавсралт

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Хорооны дарга: - Аймгийн Засаг дарга
- Зохицуулагч: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Гишүүд
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
 - Эрүүл мэндийн газрын дарга
 - Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
 - Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга
 - Статистикийн хэлтсийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн жендэр хариуцсан мэргэжилтэн